

ТӨВ ХАЛХЫН НЭГЭН АЯЛГУУНЫ НЭРИЙН УЧИР

Л.Долгоржав, магистр, ОИС

Abstract: Studying Khotgoid sub dialect will be one step to solve many complicated issues of the linguistics by inheriting outdated phrases, which are not usually seen in the literary monument and rare and interesting words only in the literary monument, but you cannot see them always in the literary language and other local dialects. Nowadays studying Khotgoid sub dialect specifically is very important for phonetics, grammar and word-lore, when many dialects of Mongolian language is increasingly tending to merge in the literary language more and more. It is essential to compare khotgoid sub dialect with other dialects, explain some interesting facts, historical events and changes of ancient and middle Mongolian language from the aspect of this sub dialect and report some linguistics issues with certain facts.

In dictionaries of Mongolian language, "Khotgoid" word is detailed as "hotuyoyid" name of Mongolian nations. And it is marked as Khotogoid, Khotokhoid, Khoidekhoid and Khoidegaid in research works about origin, language, history and nations of Khotgoid. This writings are approving that few researches made about this nation and this name.

Khotgoid nations were settled in very wide territory from Khuvsugul lake to Uvs lake in north west of Zasagt Khan Province of right hand of Khalkh in end term of XVI-XVII centuries. Also they demised their history and traditional ethics to their younger generations.

Now, Khotgoid Nations are living in some soums of Khuvsugul and Zavkhan province. In some resources, it is marked as few Khotgoid Nations are living in some soums of Uvs, Arkhangai, Dornod and Sukhbaatar Province.

By researcher's summary, Khotgoid's folk monotony is subordinated into west or western Khalkh's folk monotony and it has difference from the central Khalkh's monotony and it has independence folk monotony with special characters. In last term, Khotgoid folk monotony with difference of central Khalkh melody is fading to Khalkh monotony and it is being similar like Khalkh.

Even there are many research of history, heritage, culture, behavior as well oral dialect features about khotgoid nationality of mongolia, there are researches about lexicology and oral dialect feature. Since, this dialect phonetic, morphological features are based on dialect lexicological featured words. Also this research focused on the word «Khotgoid» that explained differently by researchers as well we tried to explain how the word «Khotgoid» related to oral dialect significance.

Түлхүүр үг: Хотгойд аман аялгуу, авиа зүй, үгийн сан, Хотгойд угсаатны нэр.

Орчин цагийн монгол хэл аялгууг гадаад болон дотоодын эрдэмтэд судлан янз бүрээр ангилан, тодорхойлсоор ирсэн бөгөөд зарим нэг эрдэмтэд Хотгойд аман аялгууг ойрд аман аялгууны нэгэн салбар аман аялгуу хэмээн үзсэн байхад, зарим нь халхын аман аялгууны салбар аман аялгуу хэмээн үзсэн байна. Тухайлбал, Академич Ш. Лувсанвандан (1970, х.) "Монгол угсаатан төв азийн асар уудам газар нутаг, европын зарим хэсэгт тасран сууж, зарим нь нүүдэл, зарим нь хагас нүүдэл, зарим нь суурьшсан аж байдлыг эрхэлж, зарим нь хоорондоо нягт холбоотой, зарим нь үлэмж тасархай байдалтай явж ирсэн тул, бие биеэсээ ялгавар бүхий олон нутгийн аялгуу, аман аялгуу болон салбарлажээ. Тиймээс орчин цагийн монгол хэл аялгууг ангилахад тэдгээр хэл аялгуугаар хэлэлцэгч ард түмний өнгөрсөн түүх, ялангуяа одоо үеийн бодит байдлыг анхаарахгүй

байж үл болно. Орчин цагийн олон монгол хэлний олон нутгийн аялгуу, аман аялгууг ангилахад хэлний шинж буюу авиа зүй, хэл зүй, үгийн сангийн онцлогийг үндэс болгож аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуу гэж ангилах онолын үндэслэлийг гаргаж, монгол хэл аялгууг төв аялгуу, дорнод аялгуу, өрнөд аялгуу, умард аялгуу гэж ангилсан ба үүний өрнөд аман аялгууны салбар аман аялгуунд хотгойдын аман аялгууг оруулсан байна. Энэхүү ангиллыг дараа үеийн олон эрдэмтэн онолын үндэслэлээ болгон монгол хэл аялгууг ангилжээ.

Эрдэмтэн Э.Вандуй, Ж.Цолоо (2008, х.14) нар орчин цагийн халхын аман аялгууг бодит материалд тулгуурлан 1. Төв халхын аман аялгуу (Улаанбаатар орчмын буюу төв дэд аман аялгуу, Говийнхон буюу халхжсан харчины дэд аман аялгуу, Архангай аймгийн халхжсан өөлдийн дэд

аман аялгуу, Өвөрхангай аймгийн Арвайхээрийн дэд аман аялгуу), 2. Халхын өрнөд аман аялгуу (Хантайширийн дэд аман аялгуу, Сартуул халхын дэд аялгуу, Хотгойдын дэд аялгуу, Илжигэн халхын аялгуу, Ховдын халхчуудын аялгуу, Говь-Алтай аймгийн халхсан дэд аялгуу), 3. Халхын дорнод аман аялгуу (Хэнтийн зүүн ба өмнөд хэсгийн дэд аялгуу, Дарьгангын дэд аялгуу) гэж 3 бүлэгт хуваажээ.

Мөн “Баруун монголын аялгууг анхлан судалсан монголч эрдэмтэн бол академич Б.Я.Владимирцов юм (Цолоо, 1962, х.152). Тэрээр халхын аялгууг монгол хэлний 1. Дорнод бүлгийн халх, 2. Хотгойдын аялгуу гэж хоёр бүлэг болгон үзээд хотгойдын бүлэг аялгуугаар Дэлгэрмөрөн, Тэс голоор нутагладаг монголчууд хэлэлцэнэ. Хотгойд хүмүүс өөрсдийгөө халх гэх боловч угтаа бол тийм биш, халхын аялгууны өрнөд буюу баруун монгол аялгуутай төстэй аялгаар хэлэлцэнэ ”хэмээн дурьдсан нь хотгойд аялгууг баруун монгол аялгуутай төстэй болохыг анх тэмдэглэсэн эрдэмтэн болно” гэжээ.

Эрдэмтэн Ж.Санжаа, Ж.Надмид нар (2008, х.15) “Монгол улсын хүн амын хэлэлцдэг монгол хэл нь халх, буриад, ойрд, өвөрлөгч хэмээх 4 нутгийн аялгуутай. Эдгээр нутгийн аялгуу нь тус бүр салбар аман аялгуутай. Хамгийн их дэлгэрсэн нь халх аялгуу бөгөөд халх аялгууг төв халх, дорнод халх, өрнөд халх гэж ангилахаас гадна авиа зүй, үг зүй, үгийн сангийн онцлогоор нь Өвөрхангайн халх, говийн халх, халхажсан өөлд, хотгойд, мянгад, дархад, дарьгангын халх гэж салбарладаг” гэж үзжээ.

Эндээс үзэхэд Хотгойдын аман аялгуу нь өрнөд буюу баруун халхын аман аялгуу гэсэн хэсэгт багтах төв халхын аман аялгуунаас хэлний талаасаа ялгаатай, өвөрмөц онцлог бүхий бие даасан аман аялгуу болох нь харагдаж байна.

Хотгойд хэмээх нэрийн үүсэл гарал, утга учрыг эрдэмтэд XIX зууны сүүл үеэс эхлэн янз бүрээр тайлбарласаар ирсэн бөгөөд, судалгаанаас харахад Хотгойд ястны угсаа гарал, түүх, ахуй

соёлын талаас нь нэлээд судалж, янз бүрийн санал, таамаглалыг дэвшүүлсэн байгаа хэдий ч энэ ястны тухай тогтсон нэг үзэл баримтлал хараахан тогтоогүй байна гэж хэлж болохоор байна.

Хотгойдууд нь XVI-XVII зууны сүүл үед Халхын баруун гар Засагт хан аймгийн баруун хойд, Хөвсгөл нуураас Увс нуур хүртэл өргөн уудам нутагт тархан суурьшиж байсан Монголын нэг ястан бөгөөд өөрсдийн гэсэн угсаатны түүх, өв соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээсэн ард түмэн юм.

Өдгөө Хотгойдууд нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг, Төмөрбулаг, Арбулаг, Тосонцэнгэл зэрэг нийт 10 суманд, Завхан аймгийн Баянхайрхан, Баян-Тэс, Тэлмэн, Нөмрөг, Тосонцэнгэл суманд нутагладаг бөгөөд зарим түүхийн эх сурвалжуудад Увс аймгийн Малчин, Наранбулаг; Тэс, Архангай аймгийн Тариат, Их Тамир; Дорнод аймгийн Матад, Халх гол; Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Эрдэнэцагаан зэрэг сумуудад цөөн тооны хотгойдууд байдаг гэж тэмдэглэсэн байна.

Тэдний түүх, соёл, зан заншлын талаар судалсан сонирхолтой мэдээ баримт, түүхийн судалгаа байгаа боловч хэлний талаас нь хэл аялгууны онцлогийн талаарх цогц судалгаа одоогоор байхгүй байна гэж хэлж болно.

Төв халх аялгуунаас ялгаа бүхий хотгойд аман аялгуу нь сүүлийн үед халх аялгуундаа нэлээд уусан, халхжсан шинжтэй байна.

Иймд энэхүү судалгааны ажилдаа Хотгойдуудын түүх, угсаа гарлын тухай асуудлыг хөндөлгүй тэдний хэл аялгууны зарим онцлогийг нэрийн учир холбогдолтой нь товч авч үзлээ.

Орчин цагийн монгол хэлний Халх аялгуунаас авианы дуудлага, аялга, үгийн сангийн хувьд зөрөө бүхий Хотгойд аман аялгууны 150 гаруй үг хэллэгийг “Хотгойд аман зохиол”(Катуу, 2010), “Хотгойд судар” зэрэг эх хэрэглэгдэхүүнээс түүвэрлэн авиа зүй, хэл зүйн дараах ажиглалтыг хийж, Хотгойд хэмээх нэрийн талаар авч үзсэн болно (Дагвадорж, Чулуун, 2007). Үүнд:

1. ОЦМХ-ний 1-р үеэс хойш үед орсон урт эгшиг ЭЭ нь (-iye, -eye) энэ аман аялгуунд, урт АА (-ā). Мөн орчин цагийн монгол хэлний Г, Л, М, Н гийгүүлэгчийн хойно орсон урт ЭЭ эгшигийг урт АА (ā)-гаар дууддаг байна. Жишээлбэл,

№	Монгол бичгийн хэлэнд	ОЦМХ-нд	Хотгойд аман аялгуунд
1	Темеге	Тэмээ	temā
2	Емегел	Эмээл	emāl
3	Тулеге	Түлээ	tulā
4	Зугер	Зүгээр	zugār
5	Емжиери	Эмжээр	emjār

2. ОЦМХ-ний үгийн 1-р үеийн бус АЙ (-ai), хос эгшиг нь урт АА болсон байгаа нь халх аялгуунаас зарим эгшгүүд хэлэгдэх байдлаараа өөр байна гэсэн үг юм. Жишээлбэл,

№	Монгол бичгийн хэлэнд	ОЦМХ-нд	Хотгойд аман аялгуунд
1	Malayai	Малгай	malgā
2	Ayil	Айл	āl
3	šay-a	Шагай	šaga□
4	Zuuzae	Зуузай	Zūzā

3. Үгийн 1-р үеэс хойш орсон урт ИЙ нь тус аман аялгуунд урт АА, буюу хэлний дундуур хэлэгдэх нэлээд уйтан урт ҮҮ болсон байна. Жишээлбэл,

№	Монгол бичгийн хэлэнд	ОЦМХ-нд	Хотгойд аман аялгуунд
1	Bitegen	Битгий	bitgē
2	Keltegei	Хэлтгий	keltgē
3	Turei	Түрий	turū

4. ОЦМХ-ний 1-р үеэс хойш орсон ОЙ-гийн хос эгшиг урт ОО болсон байна.

№	Монгол бичгийн хэлэнд	ОЦМХ-нд	Хотгойд аман аялгуунд
1	Moyai	Могой	Mogō
2	Tohoi	Тохой	Toxō
3	šohoi	Шохой	Šoxō

5. Үгийн эхний Ж,Ч гийгүүлэгчийн дараах А эгшиг нь И-ээр хэлэгддэг тохиолдол олон байна. Үүнийг эрдэмтэн Ж.Цолоо “зарим тохиолдолд И-гийн нугарал бүр мөсөн явагдаагүй бөгөөд Ж, Ч гийгүүлэгчийн дараах “И” бүр мөсөн нугараагүй ул мөр хотгойд зэрэг аялгуунд байна” гэж үзсэн байна (Цолоо, 1962, х.152).

№	Монгол бичгийн хэлэнд	ОЦМХ-нд	Хотгойд аман аялгуунд
1	Jibhulang	Жавхлан	Džiwāxlāŋ
2	Jira	Жар	Džir
3	Jirgal	Жаргал	Džirgāl
4	Jibar	Жавар	Džiwār
5	čidaburi	Чадвар	Tšidwār
6	čidal	Чадал	Tšidāl
7	čiram-a	Чармай	Tširmae

6. Үгийн 1-р үед орсон Э эгшиг хотгойд аялгуунд Ү, Ө эгшгээр сэлгэж байна. Жишээлбэл, гэнэ-гөнэ, гэлээ-гөлээ, эвэр-өвөр, гэх мэт. Мөн үгийн дунд орсон хамаршсан Н гийгүүлэгчийг М-ээр сэлгэж, унших-умших, ханцуй-хамцуй, цай унд-цай умд, ... гэх мэт. Гийгүүлэгч авианы сэлгэх үзэгдлийг доктор Ж.Санжаа нэг үгэнд орсон хэлний урдуурх хоёр гийгүүлэгч бүтэх байрын хувьд ондоошдог гэж үзсэн байдаг (Санжаа, Надмид, 2008, х.28).
7. Үгийн 1, 2-р үеийн хос эгшиг УЙ, ҮЙ нь тус аман аялгуунд урт эгшиг УУ, ҮҮ болж авиа ижилсэн байна. Жишээлбэл, шугуй-шугуу, уйтгар-уутхар, уйлах-уулах, үймүүлэх-үүмүүлэх, үйл-үүл, түймэр-түүмэр гэх мэт. Мөн үгийн 1-р үеийн Ө эгшиг дараах үеийнхээ урт ҮҮ эгшгийн нөлөөгөөр ижилсэн байна. Жишээлбэл, өгүүлэх-үгүүлэх, хөхүүр-хүхүүр.
8. Зарим тохиолдолд үгийн эхэнд орсон шүргэх Х гийгүүлэгчийг хэлдэггүй тохиолдол байна. Жишээлбэл, хот-от, хутга-утга, хутгах-утгах, хацар-ацар, хутгуур-утгуур гэх мэт. Эдгээр үгсийн дэд үед Р, Т, Х, С гийгүүлэгч орсон байгаа нь үгийн 1-р үеийн эхэнд чанга гийгүүлэгч орсноос ондоошиж Х гийгүүлэгч нь гээгдсэн байж болох талтай. Энэ онцлог бусад аман аялгуунуудад ч байдаг авианы нэг үзэгдэл юм. Зарим тохиолдолд эм эгшгийн өмнөх шүргэх Х гийгүүлэгчийг К-аар дууддаг байна. Жишээлбэл, хөөрхий-көөрхий, хэлтгий-кэлтгаа, хүн-күн, хэн-кэнгэх мэт.
9. Хотгойдын аман аялгуунд Л, Б, В гийгүүлэгч байраа сольж тонгорох үзэгдэл байна. Жишээлбэл,

- халив-хавил¹, халбага-хавлага, элбэг-эвлэг, алба-алав, цулбуур-цувлуур, олбог-овлог гэж хэлдэг байна.
10. Р, Л, М, Г, Ш зэрэг гийгүүлэгч хоорондоо байраа сольж тонгордог байна. Жишээлбэл, өртөг-өлтөг, догшин-дошгин, хярам-хямар, алчуур-арчуул гэх мэт.
11. Хотгойд аман аялгуунд авиа сугарах буюу гээгдэх үзэгдэл байна. Жишээлбэл, чавганц-чугунц, хуруувч-хурууч, хөлсөвч-хөлөвч гэх мэт.
12. Орчин цагийн монгол хэлний харъяалахын тийн ялгалын -ын, -ийн, -ы, -ий зэрэг нөхцөл нь -аа⁴, -аан⁴, -наа, -нээ гэж хэлэгддэг байна. Жишээлбэл,

№	ОЦМХ-нд	Хотгойд аман аялгуунд	Жишээ
1	Хүний	Хүнээ	Хүнээ хүн
2	Малын	Малаан	Малаан хашаа
3	Хотын	Хотаан	Хотаан
4	Хүрээний	Хүрээнаа	Хүрээнаа
5	Тогооны	Тогоонаа	Тогоонаа таг
6	Зуухны	Зуухнаа	Зуухнаа хоолаа
7	Ташааны	Ташаанаа	Ташаанаа толгой
8	Түүний	Түүнээ	Түүнээ нэр

Үүнээс гадна Хотгойд хэмээх нэрийн тухай асуудлыг авч үзлээ. Монгол хэлний тайлбар тольд (Цэвэл, 1968, х.698, Баярсайхан нарын толь, 2011, х.1484) “ХОТГОЙД” гэдэг үгийг Хотгойд (*hotuγoid*)-Монголын нэгэн ястны нэр гэж тэмдэглэсэн байгаагаас гадна Хотгойдын түүх, угсаа гарал, хэл аялгууны тухай судалгааны бүтээлүүдэд Хотогойд, Хотохойд, Хойдхойд, Хойдгайд гэх мэтээр бичсэн байна. Ингэж бичиж байгаа нь уг нэрийн талаар тогтсон санал, уг ястны талаарх судалгаа төдийлөн их байхгүйг харуулж байна гэсэн үг. Судлаачид гол төлөв угсаа гарал, түүхийн талаас нь судалж, түүхийн үйл явдалтай нь холбон тайлбарласан байна. Тэдгээр судлаачдын санал дүгнэлтийг үндсэн гурван зүйлд хуваан үзэж болохоор байна.

1. Монгол хэлний аман аялгуу, үндэстэн ястнуудын угсаа гарлын талаар ялангуяа Хотгойд ястны талаар анхлан судалсан Б.Я.Владимирцов, Г.Н.Потанин зэрэг монголч эрдэмтэд Хотогойд нь *Хото-Гайту* буюу монголжсон түрэг гаралтай угсаатан гэж угсаа гарлын талаас үзжээ (Чулуун, 2006, х.25).
2. Хотгойд хэмээх угсаатны нэр нь Дөрвөн ойрад, түүний бүрэлдэхүүнд байсан Хойд аймгаас үүсэлтэй бөгөөд *Хойд-гойд* хэмээх нэр үүсэн. Өөрөөр хэлбэл, XVI зууны

сүүл үеэс Ойрдаас Хойд аймгийн нэг хэсэг олзлогдсон хүмүүс нүүн ирж Засагт хан аймгийн хойд талаар халхчуудтай хольцолдон суужээ. Халхчууд тэднийг *Хойд-гойдууд* буюу *онцгойдууд* гэж нэрлэснээс энэ нэр үүссэн гэж Ж.Цолоо (1962, х.152), С.Пүрэвжав (1970, х.42) зэрэг эрдэмтэд үзсэн бол үүнийг эрдэмтэн Х.Нямбуу (1992) баглан Халхчуудтай холилдон суух болсон Хойдуудыг дөрвөн Ойрадын Хойдуудаас ялгахын тулд *Хойд-гойд*, *онцгой-хойд* гэж нэрлэсэн хэмээн түүхийн талаас нь үзжээ.

3. С.Чулуун (2006, х.36), Хотгойд гэх нэрийг тэдний эрхлэх аж ахуйтай нь холбон баруун монголын аман аялгуунд хонийг “хой” буюу “кой” хэмээн нэрлэх бөгөөд хойдууд нь халхын Засагт ханы араар нутаглах тэд хониор нэн баян байсан гэж сурвалжид тэмдэглэсэн байдаг. Өдгөө ч тэднийг хил залгаа орших халхчууд хонин хотгойдууд хэмээн хочлон нэрлэдэг. Тиймээс “хой” буюу хонь гэсэн үгэнд “хойд”-ыг нийлүүлэн *хотохойд* (*хойт-хойд-хотохойд*) хэмээх нэр үүссэн гэж үзсэн байна. Бид “Хотгойд” гэдэг үг нь аман аялгууныхаа онцлогтой холбоотой бий болсон болов уу гэж таамаглаж байна

¹ “Халив”- Төв халхын аман аялгууны “таг” гэсэн утгатай үг. (Тогооны халив, зуухны халив гэх мэт)

ДҮГНЭЛТ

1. ОЦМХ-ний үгийн 1-р үеэс хойш тохиолдох АЙ, ОЙ, УЙ, -гийн хос эгшиг нь Хотгойд аман аялгуунд уужим, урт АА, ОО, УУ болсон бол үгийн 1-р үед тохиолдох УЙ, ҮЙ-гийн хос эгшиг урт УУ, ҮҮ, зарим тохиолдолд урт ӨӨ болсон нь тодорхой байна. Хотгойд аман аялгуунд хос эгшиг огт байхгүй гэсэн үг биш юм. Харин хос эгшигийн хоёрдугаар эгшиг нь зарим тохиолдолд маш бүдэг сонсогддог дуудлагын өвөрмөц нэгэн онцлог;
 2. Үгийн 1-р үеийн Э эгшиг Ө, Ү-гээр сэлгэж, үгийн эхний Х-К-гээр ондоошин, В, Г, Л, М, Р, Ш зэрэг гийгүүлэгч тонгорч хэлэгдэх онцгой гойд аялгууны нэгэн онцлог;
 3. ОЦМХ-ний үгийн 1-р үеийн бус АЙ (-ai), хос эгшиг ньурт АА болсон байгаа нь халх аялгуунаас зарим эгшгүүд хэлэгдэх байдлаараа өөр байгаа төдийгүй энэ мэтчилэн дуудагддаг үг олон байгаа нэгэн онцлог;
 4. Үгийн 1, 2-р үед орсон эр эгшгүүдийг, бас зарим үгийн төгсгөлийн эм эгшгүүдийг маш уртаар уянгалуулан дууддаг аман аялгууны авиа зүйн онцлог;
 5. Хотгойдын гэгэлгэн дуунууд хэмээн алдаршсан маш олон нарийн нугалаа бүхий уянгалаг ардын дуунууд Монголын дууны урлагт тодорхой байр суурийг эзэлдэг тухай өгүүлсэн доктор Ч.Дагвадоржийн дүгнэлт зэргийг үндэслэн, Засагт хан аймагт Ойрд аймгаас нүүдэллэлэн ирсэн Хотгойд хүмүүсийн үг яриа, хэл аялгууны нь бусдаас гоц гойд байсан учраас тэднийг Ойрдын Хойд аймгаас нүүдэллэлэн ирсэн гойд содон аялгуутан, хойд гойдынхон гэж нэрлэснээс “ХОТГОЙД” гэсэн угсаатны нэр үүссэн байж болох юм гэж үзлээ.
- Эцэст нь дүгнэхэд С.Чулуун (2006, х.54), Ж.Цолоо (1962, х.152) зэрэг эрдэмтэд “Хотгойдууд нь хэл зүй болон аман аялгууны хувьд халх аялгууны бүрэлдэхүүнд багтах боловч цэвэр халх биш бөгөөд ойрад-халхын завсрын шинжтэй, захчин, урианхай аялгуутай төстэй” гэж үзсэнтэй санал нэг байна. Хэл аялгууны тухай бүтээлүүдэд захчин ялангуяа мянгад аман аялгууны үг хэллэг

Хотгойд аялгууны үг хэллэгтэй дуудлага, утгын хувьд тохирч байгаа жишээ олон байна. Ийнхүү Хотгойдын угсаа гарал, түүх, эдийн болон оюуны соёлыг тодруулан судлахын зэрэгцээ хотгойдын аман аялгууг авиа зүй, үг зүй, үгийн сан гэх мэтээр цогц байдлаар судлах шаардлагатай юм.

Хотгойд аман аялгууны үгийн сангийн бүрэлдэхүүн нь нэгэн монгол хэлтэнд багтахынхаа хувьд нийтлэг зүйл арвин боловч, он удаан жил хэсэг бүлгээрээ суурьшин, нийгмийн олон талт харилцаанд ялгаатай орсны хувьд үгийн санд онцлог зүйл арвин бий. Орчин цагийн монгол хэлний үгийн санг баяжуулах, хэлний зүй тогтол, хөгжлийн үе шатыг тодорхойлоход Хотгойд аман аялгууны үгийн сангийн онцлогийг судлах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Баярсайхан, Б. (2011). *Монгол хэлний тайлбар толь*. Улаанбаатар.
- Дагвадорж, Ч. Чулуун, С. (2010). *Хотгойд судар*. Улаанбаатар.
- Катуу, Б. (2010). *Хотгойд ардын аман зохиол*. Улаанбаатар: Соёмбо принт.
- Лувсанвандан, Ш. (1970). *Монгол хэл аялгууны учир*. ШУА, ХЗХ, Халхын аялгуу. Улаанбаатар.
- Нямбуу, Х. (1992). *Монголын угсаатны зүй*. (удиртгал). Улаанбаатар
- Пүрэвжав, С. (1970). *Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудал*. Улаанбаатар
- Санжаа, Ж., Надмид, Ж. (2008). *Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй*. Улаанбаатар. Соёмбо принт
- Цолоо, Ж. (2010). *Хотгойд аман аялгууг судалсан нь*. ШУА-ын мэдээ, №4. Улаанбаатар
- Цолоо, Ж. (1962). *Монгол бичгийн хэлийг халхын аялгуутай харьцуулсан хэл зүй*. ШУА, ХЗХ. Халхын аялгуу. Улаанбаатар
- Цэвэл, Я. (1968). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.
- Чулуун, С. (2006). *Хотгойдын түүх*. Улаанбаатар. Соёмбо принт